СҮХБААТАР ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

2026 IX

СҮХБААТАР ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



www.1212.mn

СҮХБААТАР ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

САРЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 9 дүгээр сар

Улаанбаатар хот
2026 он

ГАРЧИГ

	Ерөнхий тэмдэглэл	2
	Үндсэн үзүүлэлт	4
I.	Хүн ам	5
II.	Эрүүл мэнд	7
III.	Нийгмийн даатгал	10
IV.	Нийгмийн халамж	14
V.	Хөдөлмөр эрхлэлт	17
VI.	Төсөв	20
VII.	Гэмт хэрэг	23
VIII.	Аюулт үзэгдэл	28
IX.	Тохижилт үйлчилгээ	31
X.	Цаг үеийн мэдээ, мэдээлэл	32

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин их
- 1/X** дахин бага
- # тухайн сар
- ¹ оны эцэст
- | харьцуулагдахгүй

III. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	$=10^6$
тэрбум	$=10^9$
их наяд	$=10^{12}$
мян.	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
$м^2$	метр квадрат
$дм^2$	дециметр квадрат
$км^2$	километр квадрат
$м^3$	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори ($=10^9$ калори)
с	секунд
мин	минут
$мкг/м^3$	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас

- ┌ Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



V. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын лого дээр дарж дэлгэрэнгүй мэдээллийг MS-Excel хүснэгтээр татан авах боломжтой.

(Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой)




VI. Та өөрийн гар утаснаас QR code уншигч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

(Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой)

ХҮСНЭГТ 1. ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлтүүд	Хэмжих Нэгж	Жил		Сар		2026 I-IX / 2025 I-IX	
		2024	2025	2025 I-IX	2026 I-IX	зөрүү	хувь
Өрх	тоо	40 445	40 703	-	-	-	-
Хүн ам	тоо	143 688	141 023	-	-	-	-
o Эрэгтэй	тоо	69 283	68 179	-	-	-	-
o Эмэгтэй	тоо	74 405	72 844	-	-	-	-
Нийт халдварт өвчин	тоо	1 337	2 262	2 023	1 453	-570	-28.2
o цочмог халдварт	тоо	1 057	1 934	1 750	1 246	-504	-28.8
o халдварт өвчин	тоо	310	328	273	207	-66	-24.2
Дүүргийн төсвийн орлого	тэрбум	624	619	434.8	474.9	40.1	9.2
Дүүргийн төсвийн зарлага	тэрбум	549	632	422.5	462.1	39.6	9.4
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо (ХХҮГ)	тоо	105	53	31	121	90	3.9[1]
Нийгмийн даатгалын сангийн орлого	тэрбум	268	707	503.9	583.1	79.2	15.7
Олгогдсон нийгмийн халамжийн үйлчилгээний нийт зардал	тэрбум	96	100	75.0	79.0	4.0	5.3
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	4 458	5 196	3 846	4 163	317	8.2
Аюулт үзэгдэл	тоо	192	239	199	138	-61	-30.7
Хог тээвэрлэлт	мян.тн	61	90	70.6	45.9	-24.7	-35.0
Хог тээвэрлэлтэд зарцуулсан хөрөнгө	сая төг	4 073.2	11 022	9 262.5	4 103.3	-5 159.2	-55.7

[1]-дахин



ХҮН АМ

2026 оны эхний 9 сарын байдлаар дүүргийн хүн амын ердийн цэвэр өсөлт 6.4 байна.

2025 оны жилийн эцсийн батлагдсан дүнгээр Сүхбаатар дүүрэгт 40703 өрхийн 141023 хүн оршин сууж байгаа бөгөөд 1 өрхөд дунджаар 3.5 хүн ногдож байна.

Засаг захиргааны анхан шатны нэгж 20 хороодод хөтлөгддөг "Хүн ам, өрхийн мэдээллийн сан" (ХАӨМС)-д бүртгэгдсэнээр оны эхний 9 сард 12520 хүн шилжин ирж, 8220 хүн шилжин явсан байна.


2026 оны эхний 9 сард 1487 нярай шинээр мэндэлсний 50.3 хувь нь эрэгтэй, 49.7 хувь нь эмэгтэй хүүхэд байна.


Дүүргийн хэмжээнд 1000 хүнд ногдох төрөлт 10.3, нас баралт 4.1, ердийн цэвэр өсөлт 6.4 хувьтай байна. Ердийн цэвэр өсөлт өмнөх оны мөн үеийнхээс 0.4 нэгж хувиар өсжээ.

ХҮСНЭГТ 2. ХҮН АМЫН ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ

Үзүүлэлтүүд	Жил			Оны эхний 9 сар			2026 I-IX / 2025 I-IX	
	2023	2024	2025	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	зөрүү	хувь
Төрөлт	2 134	1 927	1 930	1 414	1 416	1 487	71	5.0
Нас баралт	757	819	785	568	566	580	14	2.5
Ердийн өсөлт	1 377	1 108	1 145	846	850	907	57	1.0
1000 хүнд ногдох								
Төрөлт	14.8	13.2	13.4	9.9	9.9	10.3	-	0.4
Нас баралт	5.3	5.8	5.5	4.0	4.0	4.1	-	0.1
Ердийн цэвэр өсөлт	9.6	7.8	8.0	6.0	6.0	6.4	-	0.4

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ





Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 71-ээр буюу 5.0 хувиар өсжээ. 1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2026 оны эхний 9 сард 580 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 14-өөр буюу 2.5 хувиар нэмэгджээ. 1000 хүнд ногдох нас баралт өмнөх оны мөн үеийнхээс 0.1 нэгж хувиар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:


Хүн амын тоо: Тодорхой хугацаанд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын тоог бэлэн болон суурин хүн амаар тооцдог.

Хүн амын ердийн цэвэр өсөлт: Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ. ЕЦӨ(ХА)=ТТ–НБТ

Төрөлт: Эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.

Нас баралт: Хүн төрөлхтний дунд гарч буй нөхөн үржихүйн үзэгдлийн нэг. Хүн амын амьжиргааны түвшин, амьдралын хэв маяг, эрүүл ахуйн нөхцөл, өвчлөл нь нас баралтын түвшинд нөлөөө үзүүлдэг учир энэ үзүүлэлтийг нас баралтын шалтгаанаар нь тодорхойлж болно.

1000 хүнд ногдох төрөлт: Нэг жилд төрсөн амьд хүүхдийн тоог тухайн жилийн дундаж хүн амын тоонд харьцуулж, 1000-аар үржүүлж тооцно.



ЭРҮҮЛ МЭНД

Халдварт өвчин өнгөрсөн оны мөн үеэс 570 тохиолдлоор буюу 28.2 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Дүүргийн хэмжээнд 2026 оны эхний 9 сард 1467 эх амаржиж, 1487 нярай шинээр мэндлэн бүртгэгджээ. Өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 61-ээр (4.3%), амьд төрсөн нярайн тоо 71-ээр (5.0%) тус тус өсжээ. Харин 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 7-гоор (29.2%) буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 3. ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ

Үзүүлэлтүүд	Жил			Оны эхний 9 сар			2026 I-IX / 2025 I-IX	
	2023	2024	2025	2024 I-IX	2025 I-IX	2026 I-IX	зөрүү	хувь
Амаржсан эхийн тоо	2 123	1 914	1 915	1 409	1 406	1 467	61	4.3
Амьд төрсөн нярай	2 134	1 927	1 930	1 414	1 416	1 487	71	5.0
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	28	15	36	8	24	17	-7	-29.2
Нас барсан хүний тоо	757	819	785	568	566	580	14	2.5

Оны эхний 9 сард нас баралт 580 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.5 хувиар нэмэгджээ. Сүүлийн 3 жилийн статистик мэдээллээс харахад жилд дунджаар 787 хүн нас барсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГАРАЛТ

Үзүүлэлтүүд	2025 I-IX		2026 I-IX		Өөрчлөлт	
	Бодит тоо	10.0 мянган хүнд ногдох	Бодит тоо	10.0 мянган хүнд ногдох	зөрүү	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	**2 023**	**142**	**1 453**	**102.3**	**-570**	**-28.2**
Цочмог халдварт өвчин	**1 750**	**122.8**	**1 246**	**87.7**	**-504**	**-28.8**
○ Цусан суулга	64	4.5	60	4.2	-4	-6.3
○ Улаан эсэргэнэ	42	2.9	28	2	-14	-33.3
○ Улаан бурхан	821	57.6	112	7.9	-709	-86.4
○ Хепатит	10	0.7	2	0.1	-8	-80.0
○ Салхин цэцэг	367	25.8	305	21.5	-62	-16.9
○ Гахайн хавдар	3	0.2	3	0.2	-	-
○ Сальмонеллёз	33	2.3	36	2.5	3	9.1
○ Ёлом	5	0.4	8	0.6	3	60.0
○ Улаануд	-	-	-	-	-	-
○ Балнад	-	-	-	-	-	-
○ Гар, хөл, амны өвчин	89	6.2	489	34.4	400	5.5
○ Хоолны хордлого	26	1.8	30	2.1	4	15.4
○ Бруцеллёз	1	0.1	-	-	-	-
○ Бусад	289	20.3	173	12.2	-116	-40.1
Халдварт өвчин	**273**	**19.2**	**207**	**14.6**	**-66**	**-24.2**
○ Тэмбүү	94	6.6	62	4.4	-32	-34.0
○ Заг хүйтэн	92	6.5	63	4.4	-29	-31.5
○ Шинээр илэрсэн сүрьеэ	71	5	74	5.2	3	4.2
○ Мөөгөнцөр	-	-	-	-	-	-
○ Трихомониаз	16	1.1	8	0.6	-8	-50.0

[1]-дахин

2026 он гарсаар эхний 9 сард дүүргийн хэмжээнд халдварт өвчнөөр 207 хүн, цочмог халдварт өвчнөөр 1246 хүн, нийт 1453 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 570 тохиолдлоор буюу 28.2 хувиар буурсан эерэг үзүүлэлтэй байна. Нийт халдварт өвчний 85.8 хувийг цочмог халдварт өвчин, 14.2 хувийг халдварт өвчин эзэлж байна.

Цочмог халдварт өвчин өнгөрсөн оны мөн үеэс 28.8 хувиар, үүнээс улаан бурхан 86.4 хувиар, хепатит 80.0 хувиар, улаан эсэргэнэ 33.3 хувиар, салхин цэцэг 16.9 хувиар, цусан суулга 6.3 хувиар, бусад өвчин 40.1 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Цочмог халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс буурахад улаан бурхан өвчин 709 (86.4%) тохиолдол, салхин цэцэг 62 (16.9%) тохиолдлоор тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

Харин гар хөл амны өвчин 5.5 дахин, ёлом 60.0 хувиар, хоолны хордлого 15.4 хувиар, сальмонеллёз 9.1 хувиар тус тус өссөн сөрөг үзүүлэлт ажиглагдлаа.

ЗУРАГ 2. ХАЛДВАРТ ӨВЧНИЙ НИЙТ ГАРАЛТ



Халдварт өвчин өнгөрсөн оны мөн үеэс 66 тохиолдлоор (24.2%), үүнээс трихомониаз 50.0 хувиар, тэмбүү 34.0 хувиар, заг хүйтэн 31.5 хувиар тус тус буурсан бол харин сүрьеэ өвчин 4.2 хувиар өсжээ.

Мөн бэлгийн замын халдварт өвчнүүд өнгөрсөн оны мөн үеийнхээс мэдэгдэхүйц буурсан байна.

Дүүргийн хэмжээнд 10 мянган хүн тутмын 88 нь цочмог халдварт өвчнөөр, 15 нь халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Тоон мэдээллээс харахад 10 мянган хүн тутмаас нийт халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 40-өөр буурчээ.

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



НИЙГМИЙН ДААТГАЛ

Ажил олгогч, даатгуулагчдаас нийгмийн даатгалын санд 583.1 тэрбум төгрөг төвлөрч, 4.7 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн Нийгмийн даатгалын газраас ирүүлсэн захиргааны статистик мэдээгээр 2026 оны эхний 9 сард ажил олгогч, даатгуулагчдаас нийгмийн даатгалын санд 583.1 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөөний биелэлт 99.2 хувьтай байна.

Орлогын төлөвлөгөө дутуу бүрдэхэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлогын биелэлт 83.5 хувьтай байгаа нь голлон нөлөөлжээ.


ХҮСНЭГТ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ

Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	
			хувь	зөрүү
	сая төгрөг			
Нийгмийн даатгалын сангийн орлого	**587 815.5**	**583 118.3**	**99.2**	**-4 697.2**
○ Тэтгэврийн даатгалын сан	484 366.1	485 474.8	100.2	1 108.7
○ Тэтгэмжийн даатгалын сан	51 896.1	52 046.4	100.3	150.3
○ ҮОМШӨ*-ний даатгалын сан	32 311.9	26 983.2	83.5	-5 328.7
○ Ажилгүйдлийн даатгалын сан	19 241.4	18 613.9	96.7	-627.5
Нийгмийн даатгалын сангийн зарлага	**265 152.3**	**265 071.9**	**100.0**	**-80.4**
○ Тэтгэврийн даатгалын сан	235 997.9	236 095.7	100.0	97.8
○ Тэтгэмжийн даатгалын сан	15 691.6	16 611.8	105.9	920.2
○ ҮОМШӨ*-ний даатгалын сан	1 644.5	1 469.6	89.4	-174.9
○ Ажилгүйдлийн даатгалын сан	11 818.3	10 894.8	92.2	-923.5

ҮОМШӨ*-үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин

Нийгмийн даатгалын санд төвлөрсөн орлогоос 265.1 тэрбум төгрөгийг зарцуулсан нь төлөвлөснөөс 80.4 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ. ҮОМШӨ*-ний даатгалын сангийн зарлага 89.4 хувийн, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 92.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь голлох нөлөөг үзүүлж байна.

ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, дүнд эзлэх хувиар




ХҮСНЭГТ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр

Үзүүлэлтүүд	Жил		Оны эхний 9 сар		Өөрчлөлт	
	2024	2025	2025 I-IX	2026 I-IX	зөрүү	хувь
	сая төгрөг					
Нийгмийн даатгалын сангийн орлого	**268 076.1**	**707 053.2**	**503 928.7**	**583 118.3**	**79 189.6**	**15.7**
o Тэтгэврийн даатгалын сан	243 230.8	588 780.5	419 460.7	485 474.8	66 014.1	15.7
o Тэтгэмжийн даатгалын сан	13 388.8	62 906.6	44 848.5	52 046.4	7 197.9	16.0
o ҮОМШӨ-ний даатгалын сан	1 935.3	32 828.1	23 447.6	26 983.2	3 535.6	15.1
o Ажилгүйдлийн даатгалын сан	9 521.2	22 538.0	16 171.9	18 613.9	2 442.0	15.1
Нийгмийн даатгалын сангийн зарлага	**278 178.9**	**305 878.7**	**229 134.7**	**265 071.9**	**35 937.2**	**15.7**
o Тэтгэврийн даатгалын сан	251 634.4	278 325.1	207 412.4	236 095.7	28 683.3	13.8
o Тэтгэмжийн даатгалын сан	14 904.1	15 101.7	11 049.3	16 611.8	5 562.5	50.3
o ҮОМШӨ-ний даатгалын сан	1 875.7	2 051.1	1 456.7	1 469.6	12.9	0.9
o Ажилгүйдлийн даатгалын сан	9 764.7	10 400.8	9 216.3	10 894.8	1 678.5	18.2
Нийгмийн даатгалын орлого, зарлагын тэнцэл	**-10 102.8**	**401 174.5**	**274 794.0**	**318 046.4**	-	-

[1]-дахин

ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, дүнд эзлэх хувиар



Нийгмийн даатгалын санд төвлөрсөн орлогоос 265.1 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд зарцуулжээ.

Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.9 (15.7%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.


Нийт зардлын 89.1 хувийг тэтгэвэр, 6.3 хувийг тэтгэмж, 0.5 хувийг ҮОМШӨ, 4.1 хувийг ажилгүйдлийн даатгалын зардал эзэлж байна.

ХҮСНЭГТ 7. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, төрлөөр

Үзүүлэлтүүд	2025 I-IX		2026 I-IX		2026 I-IX / 2025 I-IX	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
	сая төгрөг					
Нийгмийн даатгалын сангийн зарлага	**231 512.6**	**229 134.6**	**265 866.3**	**265 076.0**	**35 941.4**	**15.7**
Тэтгэврийн даатгалын сан	**207 878.9**	**207 412.4**	**235 997.9**	**236 095.7**	**28 683.3**	**13.8**
o Өндөр настны тэтгэвэр	171 499.4	170 611.1	194 419.6	194 601.1	23 990.0	14.1
o Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	14 361.3	13 162.5	14 847.6	14 834.4	1 671.9	12.7
o Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	4 399.6	4 594.8	5 540.5	5 385.3	790.5	17.2
o Цэргийн тэтгэвэр	17 592.5	19 031.1	21 163.6	21 261.4	2 230.3	11.7
o Бусад зардал	26.1	12.9	26.6	13.5	0.6	4.7
Тэтгэмжийн даатгалын сан	**12 742.3**	**11 049.3**	**15 691.6**	**16 611.8**	**5 562.5**	**50.3**
o Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	3 964.6	3 783.6	4 907.8	3 894.2	110.6	2.9
o Жирэмсэн болон амаржсаны	7 010.9	6 367.4	8 458.7	8 780.6	2 413.2	37.9
o Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж	1 529.3	898.0	2 033.1	1 472.0	574.0	63.9
o Бусад зардал	237.5	0.3	292.0	2 465.0	-	-

ҮОМШӨ*-ний даатгалын сан	**1 631.7**	**1 456.6**	**1 644.5**	**1 469.6**	**13.0**	**0.9**
o Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр	1 181.2	938.2	1 057.2	905.4	-32.8	-3.5
o Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	140.4	103.2	137.2	135.0	31.8	30.8
o Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж	165.0	377.5	307.8	387.3	9.8	2.6
o Бусад зардал	145.1	37.7	142.3	41.9	4.2	11.1
Ажилгүйдлийн даатгалын сан	**9 259.7**	**9 216.3**	**12 532.3**	**10 898.9**	**3 437.3**	**46.1**
o Ажилгүйдлийн тэтгэмж	9 259.5	9 216.2	11 818.1	10 894.7	3 437.2	46.1
o Бусад зардал	0.2	0.1	0.2	0.1	-	-

ЗУРАГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖ АВАГЧИД, төрлөөр



ХҮСНЭГТ 8. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ АВАГЧИД тэтгэвэр, тэтгэмжийн төрлөөр

Үзүүлэлтүүд	Хүний тоо		2026 I-IX / 2025 I-IX	
	2025 I-IX	2026 I-IX	зөрүү	хувь
Тэтгэвэр авагчид	**23 755**	**24 500**	**745**	**3.1**
o Өндөр насны	19 399	20 113	714	3.7
o Хөдөлмөрийн чадвар алдсаны	2 227	2 222	-5	-0.2
o Тэжээгчээ алдсаны	787	792	5	0.6
o Цэргийн тэтгэвэр	1 342	1 373	31	2.3
Тэтгэмжийн авагчид	**11 604**	**12 358**	754	6.5
o Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж	7 911	7 789	-122	-1.5
o Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж	1 466	1 699	233	15.9
o Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж	426	493	67	15.7
o Ажилгүйдлийн тэтгэмж	1 801	2 377	576	32.0

Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 20113 хүнд 194.6 (82.4%) тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1373 хүнд 21.3 (9.0%) тэрбум төгрөгийг, хөгжлийн бэрхшээлтэй 2222 хүнд 14.8 (6.3%) тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 792 хүнд 5.4 (2.3%) тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэвэр авагчдын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 745-аар (3.1%) нэмэгдсэнд өндөр насны тэтгэвэр авагч 714-өөр (3.7%) нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Харин тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан 7789 хүнд 3.9 (23.4%) тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 1699 хүнд 8.8 (52.9%) тэрбум төгрөгийг, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн 493 гишүүнд 1.5 (8.9%) тэрбум төгрөгийг, бусад зардалд 2.5 (14.8%) тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас 2377 хүнд 10.9 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг олгожээ.

Тэтгэмж авагчдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 754-өөр (6.5%) нэмэгджээ. Үүнд жирэмсэн болон амаржсан эхийн тоо 233-аар (15.9%), ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 576-гаар (32.0%) нэмэгдсэн нь голлон нөлөөлж байна.

<u>Ойлголт тодорхойлолт:</u>

Тэтгэвэр гэж: даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, тахир дутуу болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Тэтгэмж гэж: хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч гэж: хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Нийгмийн даатгалын байгууллага гэж: ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл болон хуульд заасан бусад эх үүсвэрээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох үйл ажиллагааг эрхэлж байгаа хуулийн этгээдийг хэлнэ.

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Дүүргийн хэмжээнд 100.8 мянган хүнд 79.0 тэрбум төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдожээ.


Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн захиргааны статистик мэдээгээр оны эхний 9 сард E-halamj.mn системээр дамжуулан 100.8 мянган иргэнд үйлчилгээ үзүүлж, 79.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж олгогдожээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 4.1 (5.4%) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 9. **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ,** төрлөөр

Үзүүлэлтүүд	2025 I-IX	2026 I-IX	Өөрчлөлт	
			зөрүү	хувь
Нийт олгогдсон дүн	**74 964 831.9**	**79 031 781.8**	**4 066 949.9**	**5.4**
o Тэтгэвэр	7 607 298.9	9 300 749.2	1 693 450.3	22.3
o Тэтгэмж	65 981 204.8	67 725 756.6	1 744 551.8	2.6
o Хөнгөлөлт, тусламж	1 376 328.2	2 005 276.0	628 947.8	45.7

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон нийт тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 4.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэвэр 22.3 хувиар, хөнгөлөлт, тусламж 45.7 хувиар нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлжээ.

ЗУРАГ 6. **ОЛГОГДСОН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ ТУСЛАМЖ,** хувиар



E-halamj.mn системээр олгогдсон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн нийт дүнгийн дийлэнх буюу 61.7 хувийг хүүхдийн мөнгөн тэтгэмж, 11.8 хувийг халамжийн тэтгэвэр, 11.3 хувийг асаргааны тэтгэмж, 3.2 хувийг эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж, үлдсэн 12.0 хувийг халамжийн бусад үйлчилгээ эзэлж байна.

.


ХҮСНЭГТ 10. E-HALAMJ.MN СИСТЕМЭЭР ОЛГОГДСОН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖИЙН ХЭМЖЭЭ

Үзүүлэлтүүд	Хамрагдсан хүний тоо	Гүйцэтгэл (мян.төг)
НИЙТ ОЛГОГДСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	100 779	79 031 781.8
Нийгмийн халамжийн тэтгэвэр	**2 451**	**9 300 749.2**
o Ахмад насны тэтгэвэр	528	1 831 224.1
o Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1 284	5 076 581.5
o 16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр	1	4 302.0
o Өрх толгойлсон эцэг эхийн тэтгэвэр	2	7 776.0
o Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд	636	2 380 865.6
Алдарт эх	**9 204**	**2 173 000.0**
o Эхийн алдар 2-р зэргийн одон	1 715	675 200.0
o Эхийн алдар 1-р зэргийн одон	7 489	1 497 800.0
Насны хишиг	**11 624**	**1 802 910.0**
o Насны хишиг 65-69 насны ахмад настан	4 704	466 950.0
o Насны хишиг 70-79 насны ахмад настан	4 818	714 560.0
o Насны хишиг 80-89 насны ахмад настан	1 838	505 650.0
o Насны хишиг 90-ээс дээш насны ахмад настан	264	115 750.0
Ихэр хүүхдийн тэтгэмж	**19**	**45 000.0**
o 4 хүртэлх насны 2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж (хүүхэд тус бүр)	19	45 000.0
Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж	**7 369**	**2 559 184.8**
o Жирэмсэн эхийн тэтгэмж	1 828	230 745.7
o 0-3 хүртэлх хүүхэд асарсаны тэтгэмж	5 256	1 738 203.6
o Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	285	590 235.5
Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж	**18**	**21 600.0**
o 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд олгох нэг удаагийн мөнгөн тусламж	6	7 200.0
o Гэр оронгүй болсон эсхүл гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон өрх	-	-
o Гэнэтийн аюул ослын улмаас амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх	3	3 600.0
o Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй	9	10 800.0
Алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдэл, хөнгөлөлт	**63**	**48 584.7**
o Нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардал	7	5 763.5
o Дотоодын рашаан сувилалд ирэх, буцах замын зардал	55	42 681.2
o Орон сууцны хөлс төлөхөд жилд нэг удаа	1	140.0
Асаргааны тэтгэмж	**3 577**	**8 969 438.3**
o Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа	1 932	4 317 838.3
o Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэлх насны хүүхдийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	779	2 424 842.7
o Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 16-аас дээш насны иргэнийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж	758	1 857 177.3
o Бүтэн өнчин хүүхдийг хууль ёсоор үрчлэн авсан болон хууль ёсоор асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэн	100	337 888.6
o Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие махбодийн хамгаалалт шаардлагатай болон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	6	26 092.0
o Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэн	2	5 599.4

Ахмадын хөнгөлөлт	**5 491**	**1 615 516.4**
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж	**546**	**265 650.9**
Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	**3 252**	**3 362 623.5**
o Байнгын асаргаа шаардлагатай хүүхэд	784	2 990 382.0
o Байнгын асаргаа шаардлагатай иргэн	686	107 215.1
o Байнгын асаргаа шаардлагатай ахмад	1 782	265 026.4
ОНӨТХҮ*	**0**	**0.0**
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	**56 467**	**48 792 000.0**
o 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт олгох тэтгэмж	**56 467**	48 792 000.0
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	**698**	**75 524.0**
o Насанд хүрсэн иргэн	274	37 940.0
o Хүүхэд	424	37 584.0

ОНӨТХҮ-Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ*

ЗУРАГ 7. АХМАДУУДАД ОЛГОСОН НАСНЫ ХИШИГ, насны ангиллаар



Оны эхний 9 сард 65 ба түүнээс дээш насны 11624 ахмад настанд 1.8 тэрбум төгрөгийн насны хишиг олгогдсон байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 9302 ахмадаар буурчээ.

Ойлголт тодорхойлолт

Нийгмийн халамж: гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах

боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн: гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Нийгмийн халамжийн тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Дүүрэгт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 3.9 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо 2026 оны 9 дүгээр сарын эцэст 121 болж, өмнөх оны мөн үеийнхээс 90 буюу 3.9 дахин нэмэгджээ.

Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 45-54 насныхан хамгийн их буюу 12 дахин, мөн 35-44 насныхан 6.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 11. **БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО,** насны бүлгээр, 9 дүгээр сарын эцэст

Үзүүлэлтүүд	2025 IX		2026 IX		Өөрчлөлт	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	зөрүү	хувь
Насны бүлгээр:	**31**	**19**	**121**	**80**	**90**	**3.9[1]↑**
15-24	12	6	21	13	9	75.0↑
25-34	5	4	23	17	18	4.6[1]↑
35-44	7	6	43	27	36	6.1[1]↑
45-54	2	1	24	19	22	12[1]↑
55-59	3	1	4	1	1	33.3↑
60+	2	1	6	3	4	3[1]↑

[1]-дахин

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 66.1 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.8 нэгж хувиар өсжээ.

ЗУРАГ 8. **БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД,** хүйсээр




ХҮСНЭГТ 12. **БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД,** боловсролын түвшнээр, 9 дүгээр сарын эцэст

Үзүүлэлтүүд	2025 IX		2026 IX		Өөрчлөлт, хувиар
	Бүгд	Дүнд эзлэх хувь	Бүгд	Дүнд эзлэх хувь	
Бүгд:	**31**	**100.0**	**121**	**100**	**3.9[1]↑**
Дипломын болон бакалаврын дээд ба түүнээс дээш зэрэг	12	38.7	53	43.8	4.4[1]↑
Тусгай мэргэжлийн дунд	1	3.2	6	5.0	6[1]↑
Техникийн болон мэргэжлийн анхан шат	1	3.2	9	7.4	9[1]↑
Бүрэн дунд	16	51.7	53	43.8	3.3[1]↑
Суурь	-	-	-	-	-
Бага	1	3.2	-	-	-100.0↓
Боловсролгүй	-	-	-	-	-

[1]-дахин

ЗУРАГ 9. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшнээр, 9 дүгээр сарын эцэст



Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр авч үзвэл өмнөх оны мөн үеэс дипломын болон бакалаврын дээд ба түүнээс дээш зэрэгтэй иргэдийн хувьд 12-оос 53 болж 4.4 дахин, техникийн болон мэргэжлийн анхан шатны иргэд 9.0 дахин, тусгай мэргэжлийн дунд 6.0 дахин, бүрэн дунд 3.3 дахин нэмэгдэж, харин бага боловсролтой иргэд буурчээ.

ХҮСНЭГТ 13. АЖИЛД ЗУУЛЧИЛСАН ИРГЭД, салбарын ангиллаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	2025 I-IX	2026 I-IX	2026 I-IX / 2025 I-IX хувь
Бүгд	123	203	**65.0**
o Уул уурхай, олборлолт	-	7	-
o Боловсруулах үйлдвэр	5	19	3.8[1]
o Цахилгаан, хий, уур агааржуулалт	-	-	-
o Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	-	-	-
o Барилга	19	4	-78.9
o Бөөний болон жижиглэн худалдаа, үйлчилгээ	34	59	79.5
o Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-	2	-
o Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	10	2	-80.0
o Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1	2	100.0
o Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	9	15	66.7
o Боловсрол	44	14	-68.2
o Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	-	48	-
o Урлаг, үзвэр, тоглоом наадам	-	5	-
o Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	-	8	.
o Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	-	7	-
o Мэдээлэл холбоо	-	1	.
o Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1	2	100.0
o Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	-	4	-
o Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	-	-	-
o Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	-	4	-

[1]-дахин

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраар дамжуулан ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо оны эхний 9 сарын байдлаар 203 болж, өмнөх оны мөн үеийнхээс 80 хүнээр буюу 65.0 хувиар өсжээ.

Салбараар нь авч үзвэл төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагааны салбар 66.7 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны салбар 79.5 хувиар, боловсруулах үйлдвэрлэлийн салбарынх 3.8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарт хамгийн их буюу 48 иргэн, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 25 иргэн тус тус ажилд зуучлагдан оржээ. Харин боловсрол, барилга, байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх салбарт ажилд зуучлагдсан иргэд 68.2-80.0 хүртэл хувиар буурчээ.

Мөн уул уурхай, олборлолт, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, урлаг, үзвэр, тоглоом наадам, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, хөдөө аж ахуйн салбарт нийт 203 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

<u>Тодорхойлолт:</u>

Бүртгэгдсэн ажлын байр: гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Бүртгэлтэй ажилгүй иргэн: гэж цалин хөлс, орлого олох зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн болон



цалин хөлстэй ажил эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлэхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүн юм

ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн орлого бүрдүүлэлт 474.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 144.0 тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ.

Дүүргийн төсвийн нийт орлого 2026 оны эхний 9 сард 474.9 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 144.0 (23.3%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдэж, орлогын төлөвлөгөөний биелэлт 76.7 хувьтай байна. Төсвийн нийт орлогын 97.1 хувийг татварын орлого, 2.9 хувийг татварын бус орлого эзэлж байна.

ХҮСНЭГТ 14. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үзүүлэлт	Төсвийн орлого			Үүнээс					
				Татварын орлого			Татварын бус орлого		
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Хувь
	сая төгрөг								
2026 I-IX	618 958.8	474 917.6	76.7	614 966.2	461 275.0	75.0	3 992.6	13 642.6	3.4[1]

[1]-дахин

Татварын орлогын бүрдүүлэлт 75.0 хувьтай дутуу бүрдсэн бол татварын бус орлого төлөвлөснөөс 3.4 дахин буюу 9.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын бус орлого давж биелэхэд хүү торгуулийн орлого төлөвлөснөөс 3.9 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.


ХҮСНЭГТ15. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, төрлөөр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Бүрдүүлэлт	
			хувь	зөрүү
	сая төгрөг			
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	618 958.8	474 917.6	76.7	- 144 041.2
Татварын орлого	614 966.2	461 275.0	75.0	- 153 691.2
Хүн амын орлогын албан татвар	561 158.5	415 514.1	74.0	- 145 644.4
о Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	467 613.1	295 559.0	63.2	- 172 054.1
о Үйл ажиллагааны орлогын албан татвар	5 388.0	6 388.7	118.6	1 000.7
о Хөрөнгийн орлого	51 092.0	56 282.7	110.2	5 190.7
о Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	8 019.9	11 032.6	137.6	3 012.7
о Шууд бус орлого *(нэр зааснаас бусад)*	29 045.5	46 251.1	159.2	17 205.0
Хөрөнгийн албан татвар	28 621.5	23 849.3	83.3	- 4 772.2
о Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	28 568.4	23 781.3	83.2	- 4 787.1
о Бууны татвар	53.1	68.0	128.1	14.9
Бусад төлбөр хураамж	25 186.2	21 911.6	87.0	- 3 274.6
о Улсын тэмдэгтийн хураамж	15 757.3	12 353.8	78.4	- 3 403.5
о Хог хаягдлын хураамж	3 486.7	5 733.9	164.5	2 247.2
о Түгээмэл тархацтай ашигт малтмал				-
о Газрын төлбөр	5 942.2	3 823.9	64.4	- 2 118.3
о Ус ашигласны төлбөр				-


Татварын бус орлого	3 992.6	13 642.6	3.4[1]	9 650.0
o Хүү торгуулийн орлого	3 299.0	12 749.0	3.9[1]	9 450.0
o Бусад нэр заагаагүй орлого	-	161.2	-	161.2
o Төсөвт газрын өөрийн орлого	136.2	74.0	54.3	- 62.2
o Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	557.4	658.4	118.1	101.0

[1]-дахин

ЗУРАГ 10. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг, сараар



ЗУРАГ 11. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг, сараар



ХҮСНЭГТ 16. **ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА,** сая төгрөгөөр


Төсвийн зарлагын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зарцуулалт	
			хувь	зөрүү
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	622 506.1	462 079.3	74.2	- 160 426.8
Урсгал зардлын дүн	565 445.3	405 873.7	71.8	- 159 571.6
Бараа үйлчилгээний зардал	99 605.7	72 214.7	72.5	- 27 391.0
Цалин хөлс, нэмэгдэл урамшил	13 892.9	10 284.9	74.0	- 3 608.0
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	1 816.9	1 079.3	59.4	- 737.6
Бараа үйлчилгээний бусад зардал	83 895.9	60 850.5	72.5	-23 045.4
о Байр ашиглалттай холбоотой зардал	10 108.7	6 259.1	61.9	- 3 849.6
о Бичиг хэрэг	97.5	63.4	65.0	- 34.1
о Тээвэр, шатахуун	84.8	63.7	75.1	- 21.1
о Шуудан холбоо	135.4	130.7	96.5	- 4.7
о Бусад	73 469.5	54 333.6	74.0	- 19 135.9
Нийслэлд төвлөрүүлсэн орлого	459 651.5	333 000.0	72.4	- 126 651.5
Бусад урсгал шилжүүлэг	1 062.4	659.0	62.0	- 403.4
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	5 125.7	-	-	- 5 125.7
Хөрөнгийн зардал	57 060.8	56 205.6	98.5	- 855.2

2026 оны эхний 9 сард төвлөрсөн нийт орлогоос 462.1 тэрбум төгрөг зарцуулагдсанаас 72.1 хувийг буюу 333.0 тэрбум төгрөгийг нийслэлд төвлөрүүлжээ.

Нийт зардлын 87.8 хувийг урсгал зардал, 12.2 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.
Харин урсгал зардлын 17.8 хувийг бараа үйлчилгээний зардал, 82.0 хувийг нийслэлд төвлөрүүлсэн орлого, 0.2 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Бараа үйлчилгээний зардлын 10.3 тэрбум төгрөгийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд, 1.1 тэрбум төгрөгийг ажил олгогчоос НД-д төлөх шимтгэлд, 60.8 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулжээ.

ЗУРАГ 12. **ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА**, сая төгрөг, сараар



Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

ГЭМТ ХЭРЭГ

Оны эхний 9 сард дүүргийн хэмжээнд 4163 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар өсжээ.

Дүүргийн Цагдаагийн газраас ирүүлсэн захиргааны статистик мэдээгээр 2026 оны эхний 9 сард 4163 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 317-гоор буюу 8.2 хувиар өсжээ. Үүнд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 24.4 хувь, дээрэм 18.3 хувь, хүний амьд явах эрхийн эсрэг хэрэг 11.1 хувь, залилан 7.0 хувиар нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

ЗУРАГ 13. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хэлтсээр



Нийт гэмт хэргийн 61.0 хувь нь 1-10 дугаар хороонд буюу Цагдаагийн 1-р хэлтэст, 39.0 хувь нь 11-20 дугаар хороонд буюу Цагдаагийн 2-р хэлтэст бүртгэгджээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 1-р хэлтэст 42.2 хувьтай байгаа бол 2-р хэлтэст 44.9 хувьтай байна.


Өмнөх оны мөн үеийнхээс гэмт хэргийн илрүүлэлт 1-р хэлтэст 13.7 нэгж хувиар, 2-р хэлтэст 4.6 нэгж хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 17. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр

Үзүүлэлтүүд	Хэрэг бүртгэл				2026 I-IX / 2025 I-IX	
	2025 I-IX	2026 I-IX	Үүнээс: 1-р хэлтэс	Үүнээс: 2-р хэлтэс	зөрүү	хувь
Бүгд	**3 846**	**4 163**	**2 538**	**1 625**	**317**	**8.2**
Хүний амьд явах эрхийн эсрэг	36	40	14	24	4	11.1
o Хүнийг алах	7	7	4	3	0	0.0
o Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	25	31	10	21	6	24.0
o Хүний амь насыг болгоомжгүй хохироох	4	2	2	-	-2	-50.0
Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг	674	686	449	237	12	1.8
Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг	39	37	9	28	-2	-5.1
Өмчлөх эрхийн эсрэг	624	776	450	326	152	24.4
Дээрэм	60	71	40	31	11	18.3
Залилан	1 537	1 645	1 001	644	108	7.0
Малын хулгай	-	2	-	2	2	-
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	5	1	1	-	-4	-80.0
Авто тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	209	147	82	65	-62	-29.7
Бусад	662	758	492	268	96	14.5


Гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзэхэд хүний амьд явах эрхийн эсрэг 4 (11.1%), хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг 12 (1.8%), өмчлөх эрхийн эсрэг 152 (24.4%), дээрэм 11 (18.3%), залилан 108-аар (7.0%) тус тус өссөн бол харин хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг 2 (5.1%), олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах 4 (80.0%), авто тээврийн хэрэгсэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн 62-оор (29.7%) тус тус буурчээ.

ЗУРАГ 14. ГЭМТ ХЭРГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, төрлөөр



Гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл дийлэнх буюу 39.5 хувийг залилан, 18.6 хувийг өмчлөх эрхийн эсрэг, 16.5 хувийг хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, үлдсэн 25.4 хувийг бусад гэмт хэргүүд эзэлж байна.

ЗУРАГ 15. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ангиллаар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийг ангиллаар нь авч үзвэл 89.2 хувийг хөнгөн, 10.8 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж байна. Хүнд гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеийнхээс 103 хэргээр буюу 39.7 хувиар өссөн байна.


ХҮСНЭГТ 18. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, хороогоор

Хороо	Үүнээс						Үүнээс												
	Хүний амьд явах эрхийн эсрэг	Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл	Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг	Хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй	Өмчлөх эрхийн эсрэг	Иргэдийн өмчийн	Авто тээврийн хэрэгслийн	Халаасны	Бусад	Дээрэм	Залилан	Малын хулгай	Олон нийтийн амгалан тайван	АТХХАБАЖЗ*	Бусад	Бүгд	Эзлэх хувь
БҮГД	38	7	31	686	37	776	559	13	127	77	71	1645	2	1	147	760	4163	100.0
I	2	-	2	109	1	147	97	1	41	8	5	452			30	173	919	22.1
II	1	-	1	9	-	13	12	0	1	0	1	44			1	22	91	2.2
III	2	1	1	79	2	49	31	0	15	3	11	62			6	52	263	6.3
IV	1	-	1	19	-	35	23	0	9	3	4	29			2	24	114	2.7
V	-	-	-	15	-	18	15	0	2	1	1	37			1	37	109	2.6
VI	-	-	-	38	-	34	21	0	13	0	3	86		1	16	42	220	5.3
VII	3	-	3	31	1	19	16	0	3	0	1	52			9	23	139	3.3
VIII	2	1	1	93	-	78	57	0	17	4	10	140			13	70	406	9.8
IX	3	2	1	56	5	57	47	1	7	2	4	99			4	49	277	6.7
X	4	-	4	39	3	32	25	2	5	0	4	107			8	40	237	5.7
XI	1	-	1	42	5	99	82	4	12	1	7	202			12	105	473	11.4
XII	1	-	1	13	1	20	14	1	1	4	3	34			10	18	100	2.4
XIII	3	-	3	47	5	31	26	0	0	5	4	43			10	14	157	3.8
XIV	1	-	1	13	-	14	12	2	0	0	5	41			5	8	87	2.1
XV	3	-	3	14	2	10	7	0	0	3	3	31			4	12	79	1.9
XVI	5	3	2	20	3	29	20	1	1	7	1	54			4	19	135	3.2
XVII	1	-	1	11	1	4	1	1	0	2	1	21			5	7	51	1.2
XVIII	2	-	2	11	1	20	18	0	0	2	3	57	1		2	9	106	2.5
XIX	3	-	3	16	3	42	26	0	0	16	0	20			3	13	100	2.4
XX	-	-	-	11	4	25	9	0	0	16	0	34	1		2	23	100	2.4

1-р хэлтэс: I–IX; 2-р хэлтэс: X–XX

АТХХАБАЖЗ*-Авто тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих


ЗУРАГ 16. ГЭМТ ХЭРГИЙН ГАРАЛТ, хороогоор




1-р хэлтсийн гэмт хэргийн гаралт дийлэнхдээ 1,3,6,8-р хороодод, харин 2-р хэлтсийн хувьд 10,11-р хороодод хамгийн их гарчээ.

Хотын төвийн 1,8,10,11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт залилангийн гэмт хэргийн дийлэнх буюу 54.8 хувь нь үйлдэгдсэн байна.

ЗУРАГ 17. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГСЭД, насны бүлгээр






2026 оны эхний 9 сарын байдлаар гэмт хэрэг үйлдэгсэдийн тоо 2113 болж, өнгөрсөн оны үеийнхээс 59.4 хувиар (787 хүнээр) өсжээ.

Гэмт хэрэг үйлдэгсдийн хамгийн өндөр үзүүлэлттэй нь 35-39 насны залуучууд байна.


Гэмт хэрэг үйлдэгсдийг насны бүлгээр авч үзвэл 15-34 насныхан 60.2 хувийг, 35-49 насныхан 33.6 хувийг, 50 ба түүнээс дээш насныхан 6.2 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 18. **ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГСЭД,** нийгмийн байдлаар




Гэмт хэрэг үйлдэгсдийн дийлэнх буюу 40.0 хувийг хувараа хөдөлмөр эрхлэгчид, 39.7 хувийг ажилгүй иргэд үйлджээ. Ажилгүй иргэдийн гэмт хэрэг үйлдэх нь 9.4 хувиар, харин хувараа хөдөлмөр эрхлэгчийнх 2.5 дахин нэмэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 19. **ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГСЭД,** боловсролын түвшнээр




ЗУРАГ 20. **ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРС** төгрөгөөр



Оны эхний 9 сард гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд 150.3 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 23.1 тэрбум төгрөгийг буюу 15.4 хувийг нөхөн төлүүлсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 1.5 хувиар буурчээ.

ЗУРАГ 21. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ



Оны эхний 9 сард гэмт хэргийн улмаас 3936 хүн хохирсноос 806 хүн гэмтэж, 39 хүн нас баржээ.

Хохирсон нийт иргэний 1947 буюу 49.5 хувь нь эмэгтэй, 170 буюу 4.3 хувь нь хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй 11.3 хувиар өсөж, харин хүүхэд 8.6 хувиар буурчээ.

БҮРТГЭГДСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

Оны эхний 9 сарын байдлаар гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй 43728 гомдол, мэдээлэл хүлээн авсанаас 2281 (5.2%) нь гэмт хэргийн шинжтэй, 39108 (89.4%) нь зөрчлийн шинжтэй, 2001 (4.6%) нь хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй, 338 (0.8%) нь бусад төрлийн гомдол мэдээлэл байна.

<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.




Яллагдагч: Монгол Улсын "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ

Дүүргийн нутаг дэвсгэрт аюулт үзэгдлийн нийт 138 тохиолдол бүртгэгджээ.

2026 оны эхний 9 сард дүүргийн нутаг дэвсгэрт аюулт үзэгдлийн нийт 138 тохиолдол, үүнээс гал түймрийн 126 (91.3%), үер усны 12 (8.7%) дуудлага бүртгэгджээ. Гал түймрийн нийт тохиолдлын 73.0 хувийг обьектын, 7.1 хувийг хогны, 19.9 хувийг шар өвсний түймэр эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэгдсэн гал түймэр 33-аар (20.8%), үер усны дуудлага 28-аар (70.0%) буурсан эерэг үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 22. БҮРТГЭГДСЭН НИЙТ ДУУДЛАГА, төрлөөр



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад объектын гал түймэр 31.4 хувиар, шар өвс шатсан 2.1 дахин өсөж, харин хог шатсан түймэр 88.3 хувиар буурчээ.

Дүүргийн хэмжээнд урьдчилан сэргийлэх шат дараатай арга хэмжээ авснаар үер ус, халиа дошны тохиолдол өнгөрсөн оны мөн үеэс 70.0 хувиар буюу 28 тохиолдлоор буурсан эерэг үзүүлэлт гарчээ.

ХҮСНЭГТ 19. ГАЛТ ТҮЙМЭР, ҮЕР, УСНЫ ДУУДЛАГА, өмчийн хэлбэрээр

Үзүүлэлтүүд	Нийт	Үүнээс:				
		Төр	ААНБ	Иргэний амины өмч	Худал дуудлага	Бусад (хог, шар өвс, үер)
2025 I-IX	199	-	-	70	-	129
2026 I-IX	138	-	-	92	-	46
Өөрчлөлт, хувиар	-30.7↓	-	-	31.4↑	-	-64.3↓

2026 оны эхний 9 сард иргэдийн амины өмчид гарсан гал түймэр 22 тохиолдлоор буюу 31.4 хувиар нэмэгдсэн сөрөг үзүүлэлттэй байна.


Харин бусад дуудлага (хог, шар өвс, үер) өнгөрсөн оны мөн үеэс 64.3 хувиар буурчээ.

ХҮСНЭГТ 20. ГАЛТ ТҮЙМЭР, ҮЕР, УСНЫ ДУУДЛАГА, хороогоор

Хороо	2025 I-IX							2026 I-IX						
	Бүгд	Үер ус, халиа, дошин	Гал түймэр	Үүнээс				Бүгд	Үер ус, халиа, дошин	Гал түймэр	Үүнээс			
				Объектын	ойт хээрийн	Хогны	Шар всний				Объектын	ойт хээрийн	Хогны	Шар всний
Бүгд	199	40	159	70	-	77	12	138	12	126	92	-	9	25
I	39	-	39	26	-	8	5	5	-	5	0	-	5	-
II	10	-	10	5	-	2	3	-	-		0	-	-	-
III	9	-	9	9	-	-	-	1	-	1	1	-	-	-
IV	1	-	1	-	-	-	1	2	-	2	0	-	2	-
V	-	-	-	-	-	-	-	1	-	1	0	-	1	-
VI	-	-	-	-	-	-	-	-	-		0	-	-	-
VII	-	-	-	-	-	-	-	-	-		0	-	-	-
VIII	-	-	-	-	-	--	-	1	-	1	1	-	-	-
IX	-	-	-	-	-	-	-	-	-		0	-	-	-
X	-	-	-	-	-	-	-	3	-	3	3	-	-	-
XI	-	-	-	-	-	-	-	6	4	2	2	-	-	-
XII	-	-	-	-	-	-	-	1	-	1	1	-	-	-
XIII	12	3	9	3	-	6	-	5	-	5	4	-	-	1
XIV	10	3	7		-	5	2	3	-	3	3	-	-	-
XV	16	6	10	2	-	8	-	9	1	8	6	-	1	1
XVI	31	9	22	7	-	15	-	12	-	12	11	-	-	1
XVII	10	3	7	2	-	5	-	9	1	8	6	-	-	2
XVIII	21	5	16	6	-	10	-	12	1	11	9	-	-	2
XIX	14	5	9	3	-	6	-	43	5	38	30	-	-	8
XX	26	6	20	7	-	12	1	25	-	25	15	-	-	10

Бүртгэгдсэн дуудлагыг хороодоор нь авч үзвэл байшин хорооллоос 1,4,10 дугаар хороонд 10, 11-20 дугаар хорооны гэр хорооллын бүсэд 125 буюу дийлэнх тохиолдол бүртгэгджээ.


ЗУРАГ 23. БҮРТГЭГДСЭН НИЙТ ДУУДЛАГА, хороогоор



Тодорхойлолт:

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг хэлнэ.

Гамшиг: Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.



ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ


Оны эхний 9 сард дүүргийн нутаг дэвсгэрээс 45.9 мянган тонн хог тээвэрлэж, 4103.3 сая төгрөгийн хөрөнгө зарцуулжээ.

Дүүргийн хэмжээнд сар бүр 1553.2 мян.м^2 талбайг тогтмол цэвэрлэдэг бөгөөд оны эхний 9 сард зам талбайн цэвэрлэгээнд 983.1 сая төгрөгийг зарцуулжээ. Дүүргийн нутаг дэвсгэрээс 45.9 мянган тонн хогийг тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 24.7 мянган тонноор (35.0%) буурчээ. Хог тээвэрлэлтэд нийтдээ 4103.3 сая төгрөг зарцуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 5159.2 сая төгрөг буюу 55.7 хувиар буурхад гэр хороолол, зуслан, орон сууцнаас тээвэрлэсэн хог 49.2-59.0 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 21. ТЭЭВЭРЛЭСЭН ХОГ, ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2025 I-IX	2026 I-IX	Өөрчлөлт		Зарцуулсан хөрөнгө (мян.төг)		Өөрчлөлт, хувиар
				зөрүү	хувь	2025 I-IX	2026 I-IX	
Тээвэрлэсэн хог, бүгд	**тн**	**70 643.2**	**45 918.7**	**-24 724.5**	**-35.0**	**9 262 510.8**	**4 103 311.4**	**-55.7**
o Орон сууцнаас	тн	38 688.5	21 898.3	-16 790.2	-43.4	4 798 492.4	1 965 433.5	**-59.0**
o Гэр хороллоос	тн	21 384.6	17 105.6	-4 279.0	-20.0	2 997 849.9	1 522 462.5	**-49.2**
o Зуслангаас	тн	10 570.1	6 914.8	-3 655.3	-34.6	1 466 168.5	615 415.4	**-58.0**

ЗУРАГ 24. ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, хувиар



Оны эхний 9 сард хог тээвэрлэлтэд зарцуулсан хөрөнгийн 47.9 хувийг орон сууцны, 37.1 хувийг гэр хорооллын, 15.0 хувийг зуслангийн бүсийн хог, хаягдлыг тээвэрлэхэд тус тус зарцуулсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон сууцны хог тээвэрлэлтэд зарцуулсан зардал 59.0 хувиар, гэр хорооллынх 49.2 хувиар, зуслангийн бүсийнх 58.0 хувиар тус тус буурчээ.

ЗУРАГ 25. ХОГ ТЭЭВЭРЛЭЛТЭД ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ, байршлаар, сая төгрөг



Хог тээвэрлэлтэд зарцуулсан нийт зардлын 2.0 тэрбум төгрөгийг орон сууцны, 1.5 тэрбум төгрөгийг гэр хорооллын, 0.6 тэрбум төгрөгийг зуслангийн бүсийн хогны зардал эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад орон сууцнаас тээвэрлэсэн хог хамгийн их буюу 43.4 хувиар, 16.8 тонноор буурсан үзүүлэлттэй байна.



Цаг үеийн мэдээ, мэдээлэл

ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН СТАТИСТИК
2026-2027 оны хичээлийн жил

Сүхбаатар дүүрэгт 40703 өрхийн 141023 хүн ам бүртгэлтэй оршин суугч байгаагийн 49427 буюу 35.0 хувь нь 0-17 насны хүүхдүүд байна.





СӨБ



Дүүргийн Хүн ам, өрхийн мэдээллийн санд бүртгэгдсэн нийт хүн амын 9.6 мянга буюу 6.8 хувийг 2-5 насны хүүхдүүд эзэлж байна.

2026-2027 оны хичээлийн жилд төрийн өмчийн 36, хувийн өмчийн 20, нийт 56 цэцэрлэгт 9614 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдахаар байна.

ЕБС



Дүүргийн нийт хүн амын 35146 (24.9%) нь 6-17 насны хүүхдүүд бөгөөд тэдний 51.2 хувь нь эрэгтэй, 48.8 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

2026-2027 оны хичээлийн жилд дүүргийн төрийн өмчийн 28, хувийн өмчийн 24, нийт 52 сургуульд 50623 хүүхэд суралцах урьдчилсан дүнтэй байна.



БҮЛЭГ

Танилцуулга бэлтгэсэн

	Үндсэн үзүүлэлт	Б.Анхилуун
I.	Хүн ам	Д.Амгаланбаатар
II.	Эрүүл мэнд	Д.Амгаланбаатар
III.	Нийгмийн даатгал	Т.Баттулга
IV.	Хөдөлмөр эрхлэлт	Б.Анхилуун
V.	Нийгмийн халамж	Б.Анхилуун
VI.	Гэмт хэрэг	Т.Баттулга
VII.	Аюулт үзэгдэл	Т.Баянмөнх
VIII.	Төсөв	Д.Амгаланбаатар
IX.	Тохижилт үйлчилгээ	Т.Баттулга
X.	Цаг үеийн мэдээ, мэдээлэл	Д.Нарантуяа

НЭГТГЭСЭН: Мэргэжилтэн Б.Анхилуун
ХЯНАСАН: Хэлтсийн дарга Д.Нарантуяа

Эх үүсвэр:

Сүхбаатар дүүргийн ЗДТГ болон дэргэдэх газар, хэлтэс, албадаас ирүүлсэн захиргааны статистикийн сарын мэдээ

Мэдээлэл авах холбоос:

И-мэйл: Sukhbaatar_dist@nso.mn
Вэб: www.sbd.gov.mn, www.nso.mn, www.1212.mn
Фэйсбүүк пэйж хуудас:
https://www.facebook.com/sukhbaatar.statistic

Дараагийн мэдээ тархаар хуваарь:

2026 оны 10 дугаар сарын 15

Хаяг:

14190, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг-13, 11-р хороолол,
7 дугаар хороо, Денверийн гудамж, ЗДТГ-ын байр, 204 тоот

Холбоо барих:

Утас: +976 70107098, 70107068, 70177068

/sukhbaatar.statistic sukhbaatar_dist@nso.mn 7014-7098